

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны
03 дугаар сарын 27-ний өдрийн 4/47 дугаар тушаалын Хавсралт

Зорилго: Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт “Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд төрийн бүх шатны байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулж, үр дүнг тооцох.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
/Хэрэгжүүлэх хугацаа: 2026.03.26-2026.12.01/

д/д	Зорилт Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжүүлэх газар, алба
<i>Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</i>					
1.1.	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн хэвлэлийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, youtube суваг/, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх,	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	-Компанийн цахим хуудас болон компанийн сошиал медиа хуудсаар АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухай бүр нь байршуулна. -Зах зээлийн оролцогч нарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, хууль тогтоомжийг танин мэдэх боломжоор хангасан байна.	БХГ-МОНХА, ЭБАТ
1.2.	Компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс компанийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	3 дугаар улиралд	-Хөрөнгийн зах зээлийг сурталчлах, ойлголт мэдээлэл түгээх -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар нотломжийг хавсаргах	БХГ-МОНХА, Бүх газар алба

1.3.	Компанийн эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 11-10 дугаарыг оруулан сурталчлах	-Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны тайлангийн ар хуудаст "Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10" мэдээллийн утас байршуулах	2 дугаар улиралд	-Нийт зах зээлийн оролцогчдод болон үйлчлүүлж байгаа олон нийтэд авлигын эсрэг "11-10" дугаарын уриалгыг хүргэсэн байх ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааны тайлангийн ар хуудаст "Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10" мэдээллийн утас байршуулах. -Түгээсэн нотломжийг хавсаргах	БХГ-МОНХА, ЗЗХА, ЭБАТ, ТУЗ-ийн нарийн бичиг, ҮАГ-АА,
		- Байгууллагаас зохион байгуулдаг үнэт цаасны мэдлэг олгох анхан шатны сургалтын гарын авлагын ар талын хуудаст 11-10 гэх мэдээллийн утас байршуулах	Жилдээ	-Компанийн зохион байгуулдаг үнэт цаасны мэдлэг олгох анхан шатны сургалтын гарын авлагын ар талын хуудаст 11-10 гэх мэдээллийн утас байршуулах -Түгээсэн нотломжийг хавсаргах	
1.4.	Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-Зах зээлийг сурталчилсан видео контент хийх -Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хүрээнд авлигын мэдээлэх 11-10 утсыг сурталчлах контент хийх нотломжийг хавсаргах	Эхний контентыг 2 дугаар улиралд Дараагийн контентыг 3 дугаар улиралд	-Нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгийн зах зээлийг түргэн шуурхай олон нийтэд түгээх ажлын хүрээнд зах зээлийн байгууллагуудтай хамтран видео контент хийх, -Зах зээлийг сурталчилсан контент хийх	БХГ-МОНХА, ЭБАТ Холбогдох газар, алба
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					
2.1.	"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх;	-Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; -Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; -Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.	Жилдээ	-Арилжаа зохион байгуулах зааврыг шинэчлэн найруулах -Мэдээллийн үйл ажиллагааны журмыг боловсруулан гаргах	БХГ-МОНХА, ЭБАТ, ХЗГ-БА, ХША, УУАБГ, ЗСГ-ХА Бүх газар алба

2.2.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-Салбарт бүр т үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Нээлттэй ил тод байх шударга байх, зарчмыг баримтлах - Үр дүнг тооцож, тайлагнасан байх	Жилдээ	-Компанийн соёлын судалгааг гаргах , -Ажилтнуудын ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэхэд ERP системийг ашиглах боломжийг судлах, ERP нэвтрүүлж гүйцэтгэлийн үр дүн сайжруулах талаар судлах, -АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад компанийн ажилтнуудыг авлигын эсрэг ойлголтын сургалтыг авах, -Ажилтныг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх Дүрэм журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулах, - Ёс зүйн хорооноос "ёс зүйн соён гэгээрүүлэх ажил" зохион байгуулах нь байгууллагын соёл, ажилтнуудын хандлага, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн ажлын төлөвлөх, хийх	ЗСГ-ЗА, ХА, ЭБАТ Компанийн ёс зүйн хорооны гишүүд
2.3.	Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-2026 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-ийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-тэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; - Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.	Жилдээ	-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх -Шилэн дансыг тогтмол хөтөлдөг, Тайланд мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр тусгаж, мэдээллийн агуулга сайжирсан байх -Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж зөвшөөрөл авсан байх -Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр мэдээлэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, гүйцэтгэл үр дүнг хариуцан ажиллах /цахим системээр/ хэрэгжилтийг хангах	ЗСГ-СА, БХГ-МОНХА, ЭБАТ

2.4.	Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлд холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Жилдээ	-Компанийн цахим хуудсанд санал гомдол авах цэсийг идэвхжүүлэх, -Гадны байгууллагууд болон ажилтнуудаас ирүүлсэн хүсэлт гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хэрэгжилт хангагдсан талаар тайлан мэдээ гаргах Able дотоод систем дээр тогтмол бүртгэх	БХГ-МОНХА, УАГ-МТА, ЗСГ-ЗА, ЭБАТ
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
3.1.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	-Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Нээлттэй мэдээллийн ил тод байдлын болон нээлттэй мэдээллийн shilen.gov.mn системийн хөтлөлтийн талаар арга хэмжээг авч ажиллах, -Хэрэгжилтийг тайлагнах.	Жилдээ	-Компанийн www.mse.mn цахим хуудасны ИЛ ТОД БАЙДАЛ хэсэгт авлигын нүүр хуудас хийх, -Компанийн сошиал медиа хуудсаараа авлигын эрсдэл ба авлига гаргах, авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентуудыг байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах, мэдээллийг түгээж олон нийтээс хандалт авах, -Цахим хуудсаараа дамжуулан зах зээлийн мэдээллийг түргэн шуурхай хууль журмын хүрээнд Үүнд: -Уул уурхайн арилжааны өдөр тутмын мэдээлэл, -Арилжааны өдөр тутмын мэдээлэл -Бүртгэлтэй ХК, Гишүүн бүртгэлтэй компаниудын мэдээлэл, -ХЭ нарт тухай бүр нь мэдээллийг байршуулах, -Компанийн цаг үеийн мэдээллийг тухай бүр мэдээлэх, -Компанид мөрдөгдөж байгаа дүрэм журмыг тогтмол шинэчлэн цахим хуудаст байршуулах Үүнд: үйлчилгээгээ цахим, ил тод байдлыг	БХГ-МОНХА, ЭБАТ, ХЗГ-БА, ХША, УУАБГ, УАГ-АА, МТА, ЗСГ-ХА, ТУЗ-нарийн бичиг

				нэмэгдүүлэх, мэдээллийн хэлбэр, давтамж сайжирсан байх	
3.2.	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэрэгжүүлсэн байх;	Жилдээ	3.2.1. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, 3.2.2. Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмж 3.2.3. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэргэжлийн газрууд, дээд газруудаас өгсөн зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, -Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шат дараалсан хяналтыг хэрэгжүүлэх, -Компанийн ажилтнуудын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил дутагдлыг гаргуулахгүй байх үүднээс зөвлөмж өгсөн, эрсдэлийг тодорхойлуулан, зөвлөмж, тайлбарыг гаргуулан ажилтнуудыг хүнд сурталгүй авлига, ашиг сонирхлоос ангид байх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авсан байх	ЗСГ-ЗА, ЗСГ-ХА, Дотоод хяналтын мэргэжилтэн,
3.3.	Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	-Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; -Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ онцлогт тохирсон байх.	Жилдээ	Компанийн цахим хуудас болох www.mse.mn цахим хуудаст САНАЛ ГОМДОЛ хүлээн авах цэс байршуулж, хүлээн авах, www.mse.mn цахим хуудаст иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх. /Цахим хуудас дээр мэдээллийг байршуулсан байх	ЗА-ХА, ЭБАТ, БХГ-МОНХА, ҮАГ-МТА ХЗГ-БА,

3.3.1	Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд тогтмол мэдээлэх	Төрийн аудитын байгууллагаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээлсэн байх,	Жилдээ	-Олон нийтэд төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад гэсэн мэдээллийг мэдээлэх	ЗСГ-СА
3.3.2	Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх,	-2-оос доошгүй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан байх, -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд зохих арга хэмжээ авч үр дүнд хүрсэн байх, -Тайланд нотломжийг хавсаргасан байх,	Жилдээ	Хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагууд болон уул уурхайн арилжаанд оролцогч байгууллагуудад зах зээлийн талаарх ойлголт, авлигаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах, уулзалт зохиох	ЗСГ-ЗА-ХА, ЭБАТ, ХЗГ-ХША, БА БХГ-МОНХА,
3.3.3	Байгууллагын хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах;	-Мэдээллийг тухай бүрд нь шинэчлэх; -Тайланд шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг байгууллагын дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй олон нийтэд түгээн ажиллаж байна.	БХГ-МОНХА, ЭБАТ, ХЗГ-БА, ХША, УУАБГ, ТУЗ-нарийн бичиг, ЗСГ-СА, ХА
3.3.4	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хийж үр дүнг тооцон ажилласан байх;	-Дотоод хяналт шалгалтыг хийсэн байх; -Дотоод хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Хяналт шалгалтын мөрөөр илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгснөөр хариуцлагыг өндөржүүлэх, зөрчлийн шалтгаан хамааран эрсдэлийг тодорхойлон, зөрчил дутагдлыг давтан гарахгүй байна.	Газрын захирлууд Дотоод хяналтын мэргэжилтэн

Жич: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухайн төрийн байгууллага хариуцах ба төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай захиран зарцуулж ажиллах нь зүйтэй.

Төлөвлөгөөний талаар khutulbur.iaас.mn цахим хуудсанд нэвтрэн орж 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө цэс рүү өөрийн байгууллагын нэрээр танилцан хүснэгтийг татан авах боломжтой, мөн төлөвлөгөөний батлагдсан хувилбарыг Сангийн яамны ЭБАТ-д хүргүүлэхийг анхаарна уу.